ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2023/109/А/-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Хоо өрлөгийн үрс аудит ХХК<br>Аудитор: А.Оюундэлгэр<br>Утас: 99306289<br>цахим хаяг: a_oyund@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .......... 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .......... 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .......... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .......... 12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 13
**3.5.1 Төсвийн төлөвлөлт** .......... 13
**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** .......... 13
**3.5.3 Нэмэлт төсөв** .......... 13
**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**
**4. АУДИТЫН ТАЙЛАН** .......... 14
**4.1 Ерөнхий зүйл** .......... 14
**4.2 Материаллаг байдал** .......... 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** .......... 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** .......... 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .......... 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** .......... 15
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..........
**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** .......... 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 15
5.1 Залруулсан алдаа .......... 15
*Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй*
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БШУГ | Боловсрол шинжлэх ухааны газар |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.14 № 02/35

танай ____________-ны №_____________-т

ДУУТ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд цэцэрлэгийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮБД-4 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

C21020180

Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нийт 100 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 78 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамруулж биелэлт 78.0 хувьтай байна.

Тус байгууллага нь тайлант онд 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 100.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. “

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,505,145.00** | **29,456,143.00** |
| **33** | **АВЛАГА** | 2,098,138.00 | 3,618,374.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 79,764.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 2,018,374.00 | 3,618,374.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,018,374.00 | 2,268,374.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,407,007.00 | 23,171,775.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 246,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 246,000.00 | - |
| **354** | **Хангамжийнматериал** | 20,161,007.00 | 23,171,775.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,430,418.00 | 6,589,970.00 |
| 35460 | Хүнсний материал | 8,730,589.00 | 8,344,375.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **360,062,551.30** | **348,128,358.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 360,062,551.30 | 348,128,358.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 355,882,051.46 | 344,062,109.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 389,049,187.00 | 389,049,187.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,990,622.86) | (70,461,828.06) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 40,213,672.00 | 40,213,672.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (31,810,408.00) | (34,501,246.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 46,732,480.00 | 56,732,480.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,728,256.68) | (37,386,155.72) |
| 39217 | Ном | 416,000.00 | 416,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 4,180,499.84 | 4,066,249.76 |
| 39301 | Програм хангамж | 532,000.00 | 532,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (303,500.16) | (417,750.24) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,952,000.00 | 3,952,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **382,567,696.30** | **377,584,501.98** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **382,567,696.30** | **377,584,501.98** |
| **51** | **Засгийн газрын хувьоролцоо** | 382,567,696.30 | 377,584,501.98 |
| **512** | **Хуримтлагдсанүрдүн** | (411,928,773.70) | (416,911,968.02) |
| 51210 | Өмнөх үеийн үрдүн | (411,928,773.70) | (411,928,773.70) |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -4,983,194.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,767,741.00 | 1,767,741.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **382,567,696.30** | **377,584,501.98** |

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **245,725,622.00** | **297,409,830.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,000,000.00** | **18,613,430.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,000,000.00 | 18,613,430.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,000,000.00 | 18,613,430.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,000,000.00 | 18,613,430.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **240,725,622.00** | **278,796,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 218,120,500.00 | 229,272,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 218,120,500.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,862,722.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 223,802.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,638,920.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөссанхүүжих** | 13,742,400.00 | 49,524,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,742,400.00 | 49,524,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **264,468,709.84** | **302,393,024.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **264,468,709.84** | **302,393,024.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 247,276,270.84 | 302,243,318.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166,566,783.00 | 183,992,275.00 |
| 210101 | Үндсэн цалин | 145,972,823.00 | 129,665,502.00 |
| 210102 | Нэмэгдэл | 3,170,746.00 | 41,371,634.00 |
| 210104 | Урамшуулал | 17,423,214.00 | 12,955,139.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,289,936.00 | 22,758,524.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,953,001.01 | 15,639,332.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,664,266.06 | 1,839,922.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,331,412.85 | 1,471,937.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 303,816.96 | 337,790.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,037,439.12 | 3,469,541.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,101,400.00 | 33,310,990.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 585,458.00 | 1,270,590.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,515,942.00 | 32,040,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 906,302.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 150,500.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 423,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,600.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 195,802.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 120,800.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 10,507,700.00 | 22,394,014.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,192,300.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 8,462,450.00 | 22,394,014.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 852,950.00 | - |
| **2106** | **Эдхогшил, урсгал засварын зардал** | 1,664,000.00 | 165,000.00 |
| 210604 | Урсгалзасвар | 1,664,000.00 | 165,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 71,900.00 | 118,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 71,900.00 | 118,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,252,948.00 | 458,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,928,948.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 25,915,301.84 | 39,046,315.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,600.00 | 14,620,508.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,650,350.00 | 2,491,615.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,261,351.84 | 21,934,192.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,192,439.00 | 149,706.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,530,920.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,530,920.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,661,519.00 | 149,706.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,661,519.00 | 149,706.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(18,743,087.84)** | **(4,983,194.32)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(18,743,087.84)** | **(4,983,194.32)** |

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээнийн өөц | Хуримтлагдсандүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 792,728,729.00 | 1,767,741.00 | (411,928,773.70) | | 382,567,696.30 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **792,728,729.00** | **1,767,741.00** | **(411,928,773.70)** | - | 382,567,696.30 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **792,728,729.00** | **1,767,741.00** | **(411,928,773.70)** | - | 382,567,696.30 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **792,728,729.00** | **1,767,741.00** | **(411,928,773.70)** | - | 382,567,696.30 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **792,728,729.00** | **1,767,741.00** | **(411,928,773.70)** | - | 382,567,696.30 |
| D08 | Тайлант үеийн үрдүн | - | - | (4,983,194.32) | | (4,983,194.32) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **792,728,729.00** | **1,767,741.00** | **(416,911,968.02)** | - | 377,584,501.98 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **240,725,622.00** | **278,796,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **240,725,622.00** | **278,796,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 218,120,500.00 | 229,272,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 218,120,500.00 | - |
| **1311** | **Нэмэлтсанхүүжилтийнорлого** | 8,862,722.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 223,802.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,638,920.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөссанхүүжих** | 13,742,400.00 | 49,524,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 13,742,400.00 | 49,524,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **240,725,622.00** | **276,130,406.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **240,725,622.00** | **276,130,406.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **223,533,183.00** | **275,980,700.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 166,646,547.00 | 183,912,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 94,862,356.00 | 129,585,722.00 |
| 210102 | Нэмэгдэл | 59,947,613.00 | 41,371,634.00 |
| 210104 | Урамшуулал | 11,836,578.00 | 12,955,139.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,289,936.00 | 22,758,540.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,008,300.00 | 15,820,797.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,545,700.00 | 1,794,096.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,127,825.00 | 1,388,525.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 234,500.00 | 341,529.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,373,611.00 | 3,413,593.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,077,400.00 | 35,084,696.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 585,458.00 | 2,720,296.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,491,942.00 | 32,040,400.00 |
| 210303 | Цэвэр ,бохир ус | | 324,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,048,002.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 150,500.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 423,600.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,600.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 331,802.00 | - |
| 210406 | Багаүнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 126,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 10,028,350.00 | 25,107,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,900.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 9,590,250.00 | 25,107,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 396,200.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,664,000.00 | 415,294.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,664,000.00 | 415,294.00 |
| **2107** | **Томилолт, зочнызардал** | 71,900.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 71,900.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,243,848.00 | 444,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,919,848.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэлтогтоох | 324,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 444,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,463,200.00 | 8,257,875.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,168,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,463,200.00 | 3,089,875.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,192,439.00** | **149,706.00** |
| **2132** | **Бусад урсгалшилжүүлэг** | 8,530,920.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,530,920.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 8,661,519.00 | 149,706.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,661,519.00 | 149,706.00 |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийнзасгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсантөлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 278,796,400.00 | 275,980,700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 278,796,400.00 | 275,980,700.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 278,796,400.00 | 275,980,700.00 |
| **2101** | **Цалинхөлс болон нэмэгдэлурамшил** | 186,491,400.00 | 183,912,495.00 |
| 210101 | Үндсэн цалин | 146,541,600.00 | 129,585,722.00 |
| 210102 | Нэмэгдэл | 33,344,400.00 | 41,371,634.00 |
| 210104 | Урамшуулал | 6,605,400.00 | 12,955,139.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,311,600.00 | 22,758,540.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,097,200.00 | 15,820,797.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,778,100.00 | 1,794,096.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,468,400.00 | 1,388,525.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 360,900.00 | 341,529.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,607,000.00 | 3,413,593.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,017,800.00 | 35,084,696.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,577,400.00 | 2,720,296.00 |
| 210302 | Түлш, халаалт | 32,040,400.00 | 32,040,400.00 |
| 210303 | Цэвэр, бохирус | 400000.00 | 324,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,108,000.00 | 25,107,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,108,000.00 | 25,107,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 25,108,000.00 | 25,107,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 165,000.00 | 415,294.00 |
| 210604 | Урсгал засвар | 165,000.00 | 415,294.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 444,000.00 | 444,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 444,000.00 | 444,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,258,600.00 | 8,257,875.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,168,600.00 | 5,168,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,090,000.00 | 3,089,875.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 278,796,400.00 | 278,646,694.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 229,272,000.00 | 229,272,000.00 |
| 131001 | Улсын төсвөөссанхүүжих | 229,272,000.00 | 229,272,000.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 49,524,400.00 | 49,374,694.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 49,524,400.00 | 49,374,694.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 13.00 | 13.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 7.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1.00 | 1.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 1.00 | 1.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1.00 | 1.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **13.00** | **13.00** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 8.00 | 8.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

2021-2022 оны хичээлийн жилд "Хүүхдийн бүтээлч үйлийг дэмжсэн орчин бий болгон, сургалт үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангахад анхаарч ажилласан байна. Танхимын сургалтаар 5 бүлэгт 2-5 насны 95 хүүхдийг хамруулан СӨБ олгон ажилласан ба тус хичээлийн жилд 5 настай 20, 3- 4 настай 75 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулсан.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөрийн тухай, Боловсролын тухай, сургуулийн өмнөх боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай багц, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай хууль , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- "Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- "Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам" Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- "Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна .

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 2665.9 | 2665.9 |
| Авлага | 2098.1 | 3618.4 | 1520.3 |
| Бараа материал | 20407.0 | 23171.8 | 2764.8 |
| Үндсэн хөрөнгө | 360062.5 | 348128.4 | -11934.1 |
| **Нийт хөрөнгө** | **382567.6** | **377584.5** | **-4983.1** |
| Өр төлбөр | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **382567.6** | **377584.5** | **-4983.1** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **382567.6** | **377584.5** | **-4983.1** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Авлагын эхний үлдэгдэл 2 сая төгрөг байсан ба тайлант онд 1.5 буурч 3.1 сая төгрөгөөр өссөн нь хүнсний нөөц үүсгэх зорилгоор "Улсын буян" ХХК-д 1.3 сая ,иргэн Ц.Оюунчимэгт 1.7 сая төгрөгийн хүнсний материалын үнэ шилжүүлсэн боловч материалаа хүлээж аваагүйгээс үүссэн байна.
- ✓ Бараа материал өмнөх оноос 2.7 сая төгрөгөөр өссөн нь хүүхдийн хоолны мах нөөцөлсөнтэй холбоотой байна
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 11.9 сая төгрөгөөр буурсан нь элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 244.5 сая, орон нутгийн төсвөөс 52.5 сая нийт 297.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 18.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ ньМУЗГ-ын 2022 оны 91 тоот тогтоолоор хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, батлагдсан хуваарьт нийцүүлэн сар бүр сургалтын байгууллагад олгож байгаа, нэг хүүхдэд ногдох зардлын дундаж нормативаар олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны эхэнд улсын төсвөөс 178.5 сая төгрөг батлагдаж ирснийг 50.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон нь боловсролын байгууллагын багш ажилчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 278.7 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 278.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 275.9 сая төгрөг буюу 98.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2101 | 186491.4 | 183912.4 | 2578.9 | 98.62 |
| 2 | 2102 | 23311.6 | 22758.5 | 553.0 | 97.63 |
| 3 | 2103 | 35017.8 | 35084.6 | -66.8 | 100.19 |
| 4 | 2105 | 25108.0 | 25107.8 | 0.2 | 100 |
| 5 | 2106 | 165.0 | 415.2 | -250.2 | 251.6 |
| | 2108 | 444.0 | 444.0 | - | 100 |
| 6 | 2109 | 8258.6 | 8257.8 | 0.7 | 99.99 |
| | **Дүн** | **278796.4** | **275980.7** | **2815.7** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөвтэй холбоотой нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ гараагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Дуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл,түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хоо өрлөгийн үрс аудит ХХК-ийн захирал, аудитор А.Оюундэлгэр 2023 оны 1 дүгээр сарын 20-нээс 2023 оны 02 дүгээр сарын 16–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2023 оны 01 дүгээр сарын 06 өдрийн 01 албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оныж илийн эцсийн тайлангийн нийт орлого 245.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон шалтгаан нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоор тогтоосонтой холбоотой байна.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа119 мэдээллийг хугацаандаа оруулж шилэн дансны сайтад байршуулсан байна. Хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 4.5 өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 2 | 2925.3 | 2 | 2925.3 | 100 |
| Нийт дүн | 2 | 2925.3 | 3 | 2925.3 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4.7 сая төгрөгийн зөрчил илэрч 1.7 сая төгрөгийн зөрчилд акт бичиж, 3.0 сая төгрөгийн алдаанд 1 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Мөнгөн хөрөнгийн журнал хуулганаас бараа материал худалдан авалтыг гарсан гүйлгээтэй тулган шалгахад 2022.08.01-нд иргэн Ц.Оюунчимэгт махны үнэ шилжүүлсэн боловч материалаа нийлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах *заалт зөрчсөн байна.* Мах нийлүүлээгүй тул Ц.Оюунчимэгээр төлүүлэхээр 1750.0 акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Төсвийн орлого зардалтай холбоотой асуудал**

***Илрүүлэлт:*** Мөнгөн хөрөнгийн журналыг тайлангийн санхүүжилттэй тулган шалгахад аймгийн Засаг даргын нөөцөөс өвөлжилтийн бэлтгэл хангах зориулалтаар өгсөн 3,0 сая төгрөгийн нэр данс зөрүүгээр гаргаж, зардлын эрх нээгдээгүй байхад нэр данс зөрүүтэй гэж гүйлгээ хийж зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5.бүх орлого; 14.4.6. бүх зардал; заалтууд зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж:Санхүүгийн т****айланд орлого зардлыг бүрэн илэрхийлж байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

сая.төг

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дуут сумын цэцэрлэг | 2 | 4.7 | | | 1 | 1.7 | 0 | 0 | 1 | 3.0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ХОО ӨРЛӨГИЙН ҮРС АУДИТ ХХК-НЫ

АУДИТОР: А.ОЮУНДЭЛГЭР